

2018 ОНЫ 6 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 9 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ, СЭМҮТ, НЭМГ, УАУТ/ мэдээ ирүүлсэн.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2018 оны 6 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ амбулаторийн үзлэг хүлээгдэлтэй ажилласан бол УГТЭ-ийн 2 кабинетэд хүлээгдэл бүртгэгдсэн бөгөөд өмнөх сарын хүлээгдлээс нэмэгдсэн байна. УХТЭ-ийн амбулаторийн хүлээгдэл буурсан байна.

УНТЭ-ийн амбулаторийн 12 кабинетэд нийт 287 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж өмнөх сарын хүлээгдлээс 116 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнээс: Бөөрний кабинетэд 2 үйлчлүүлэгч, зүрх судасны кабинетэд 11 үйлчлүүлэгч, уушигны кабинетэд 2 үйлчлүүлэгч, мэс заслын кабинетэд 1 үйлчлүүлэгч, нүдний кабинетэд 11 үйлчлүүлэгч, чих хамар хоолой 9 үйлчлүүлэгч, мэдрэл судлалын кабинетэд 32 үйлчлүүлэгч, урологийн кабинет 31 үйлчлүүлэгч, хоол боловсруулах эрхтэн судлал 78 үйлчлүүлэгч, үе судлалын кабинетэд 103 үйлчлүүлэгч, цус судлалын кабинет 1 үйлчлүүлэгч, арьсны өвчин судлалын кабинетэд 6 үйлчлүүлэгч, тус бүр 1-7 хоногийн хугацаатай хүлээгдэлд бүртгэгджээ. 2 кабинет хүлээгдэлгүй ажиллаж байна.

УХТЭ-т нийт 11 кабинетэд 152 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Амбулаторийн хүлээгдэл өнгөрсөн сард 11 кабинетэд нийт 156 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 4 үйлчлүүлэгчээр буурсан байна.

Үүнд: Бөөр судлалын кабинетэд 14, зүрх судасны кабинетэд 15 үйлчлүүлэгч, уушигны кабинетэд 6 үйлчлүүлэгч, мэс заслын кабинетэд 15 үйлчлүүлэгч, мэдрэл судлал 24 үйлчлүүлэгч, нүдний кабинет 7 үйлчлүүлэгч, хоол боловсруулах эрхтэн судлал 51 үйлчлүүлэгч, чих хамар хоолойн кабинетэд 7 үйлчлүүлэгч, урологийн кабинетэд 1 үйлчлүүлэгч, булчирхайн кабинетэд 13 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн кабинет 10 үйлчлүүлэгч тус тус 1-3 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. 12 кабинетын 298 үйлчлүүлэгч өдөртөө хүлээгдэлгүй үйлчлүүлсэн байна.


УГТЭ-т 2 кабинетэд 103 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Зүрх судасны кабинетэд 55 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 30 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн, мэдрэлийн кабинетэд 48 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 12 кабинетад 499 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

ХСҮТ-ийн амбулаторийн 10 кабинетэд нийт 87 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 18 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнээс: элэг цөс нойр булчирхайн кабинет 12 үйлчлүүлэгч, хими эмчилгээний кабинет 5 үйлчлүүлэгч, цээжний хөндийн мэс засалд 9 үйлчлүүлэгч, эмэгтэйчүүдийн мэс заслын кабинетэд 22 үйлчлүүлэгч, ерөнхий мэс заслын кабинет 15 үйлчлүүлэгч, толгой хүзүүний мэс заслын кабинетэд 4, туяа эмчилгээний кабинетэд 13 үйлчлүүлэгч, хөнгөвчлөх эмчилгээнд 2, гепатологийн кабинет 2, ангиографийн кабинетэд 3 үйлчлүүлэгч тус бүр 1-7 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 15 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

/ Амбулаторит хүлээгдэж буй үйлчлүүлэгчдийн тоо нь ХСҮТ-н амбулаторит тухайн өдөр анх удаа үзүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдийн мэдээлэлд үндэслэн хүлээгдлийн мэдээг гаргав/

ЭХЭМҮТ-ийн амбулаторийн 5 кабинетэд 181 хүлээгдэл бүртгэгдсэн байна. ХБЭЭСК-д 37 үйлчлүүлэгч, мэдрэл-2 кабинетэд 34 үйлчлүүлэгч, нүдний эмгэг судлалын кабинетэд 38 үйлчлүүлэгч, хараа хамгаалах кабинетэд 26 үйлчлүүлэгч, чих хамар хоолойн кабинетэд 46 үйлчлүүлэгч тус тус 1-7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 6 үйлчлүүлэгч байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 6-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2018 оны 6 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн рентген 203 үйлчлүүлэгч 1-7 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 14 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хэвлийн эхо 202 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 136 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Зүрхний цахилгаан бичлэг 5 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Тархины цахилгаан бичлэг хийлгэхээр 7 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээж үйлчлүүлжээ. MRI шинжилгээ 47 үйлчлүүлэгч 15-аас дээш хоног, захын судасны ЭХО 33 үйлчлүүлэгч, радиоимунологи 52 үйлчлүүлэгч, КТГ 1 үйлчлүүлэгч 2-14 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т рентген зураг авахуулахаар 55 үйлчлүүлэгч 1-14 хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 20 үйлчлүүлэгчээр буурсан байна. Хэвлийн эхо 70 үйлчлүүлэгч хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 5 үйлчлүүлэгчээр буурсан, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 14 үйлчлүүлэгч хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 2 үйлчлүүлэгчээр буурсан, тархины цахилгаан бичлэг 1 үйлчлүүлэгч, дурангийн шинжилгээ 20 үйлчлүүлэгч, доплерографийн шинжилгээ 4 үйлчлүүлэгч, нүдний угийн шинжилгээ 1 үйлчлүүлэгч, MRI шинжилгээнд орохоор 2 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. 147 үйлчлүүлэгч өдөртөө үйлчлүүлсэн байна.


УГТЭ-т доплерографийн шинжилгээнд 8, зүрхний эход харуулахаар 4 үйлчлүүлэгч, рентген 33 үйлчлүүлэгч, зүрхний цахилгаан бичлэг 63 үйлчлүүлэгч,

хэвлийн ЭХО 58 үйлчлүүлэгч, тархины цахилгаан бичлэг 9 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 109 үйлчлүүлэгч байна.


ХСҮТ-д анх удаа үзүүлэхээр дугаар авсан 223 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 82 үйлчлүүлэгч, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 91 үйлчлүүлэгч, 1-6 хоногийн хүлээгдэлтэй 50 үйлчлүүлэгч байна. Үүнд: Рентген харалт 30, уушигны дуран 1, бүдүүн шулуун гэдэсний дуран 3, ходоодны дуран 26, хэвлийн ЭХО 81 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 237 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 130 өдөртөө, 33 үйлчлүүлэгч 1 хоног, 29 үйлчлүүлэгч 2 хоног, 34 үйлчлүүлэгч 3-6 хоног, 11 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн оношлогооны кабинетийн 6-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний 4, 5, 6-р сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/




Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2018 оны 6 дугаар сард УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 528 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: цусны ерөнхий шинжилгээ 54, шээсний ерөнхий шинжилгээ 46, биохимийн шинжилгээ 274, бактериологийн шинжилгээ 64, иммунологийн шинжилгээ 66, коагулограммын шинжилгээ 15, ДОХ/сериологи 6, цитологи 3 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 434 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 196 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд: цусны ерөнхий шинжилгээ 74, шээсний ерөнхий шинжилгээ хүлээгдэлгүй, биохимийн шинжилгээ 107 үйлчлүүлэгч, бактериологи иммунолог, серологи, цитологи хүлээгдэлгүй, коагулограммын шинжилгээ 15 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 233 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 6-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2018 оны 6 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, УАУТХ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн.

УНТЭ-т 6-р сард нийт 13 үйлчлүүлэгч 7 хоногоос 1 сарын хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: Эрүү нүүрний мэс заслын тасагт 8 үйлчлүүлэгч, дотоод шүүрлийн тасагт 5 үйлчлүүлэгч 7 хоногоос 1 сар ба түүнээс дээш хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УХТЭ-т 6-р сард 282 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр 1-14 хүртэл хоногийн хугацаанд хүлээсэн байна. Үүнд: Бөөр судлалын тасагт 6 үйлчлүүлэгч, зүрх судасны тасаг 123 үйлчлүүлэгч, уушигны тасаг 11 үйлчлүүлэгч, хоол боловсруулах эрхтэн

судлалын тасагт 46 үйлчлүүлэгч, мэс засал 86 үйлчлүүлэгч, мэдрэлийн тасагт 10 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т 6-р сард нийт 150 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: мэдрэлийн мэс засалд 58 үйлчлүүлэгч 1-30 хоног, зүрх судасны тасагт 25 үйлчлүүлэгч, бөөр судлалын тасагт 7 үйлчлүүлэгч, мэдрэлийн тасаг 22 үйлчлүүлэгч тус тус 1-30 хоногийн хугацаанд, хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 6 үйлчлүүлэгч, уламжлалтын тасагт 2 үйлчлүүлэгч 1-6 хоног, чих хамар хоолойн тасагт 20 үйлчлүүлэгч, нүд судлалын тасагт 10 үйлчлүүлэгч 7-30 хоног тус тус хүлээж үйлчлүүсэн байна.

ЭХЭМҮТ-ийн эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 6 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн.


ХСҮТ-д 6-р сард нийт 47 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 11 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 8 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 14 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 12 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 2 үйлчлүүлэгч байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг. Хэвтэх яаралтай шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг. Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна. Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.

УАУТХ-д уламжлалт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 41 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хугацаанд хүлээж байгаа 59 үйлчлүүлэгч, 7-14 хоног 67 үйлчлүүлэгч буюу нийт 167 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 41 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хугацаанд 28 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хугацаанд 27 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 25 үйлчлүүлэгч буюу нийт 93 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

Сүүлийн 6 сарын хугацаанд СЭМҮТ-ийн неврозын тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/



Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харьяа 8 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн мэдрэл, Налайх дүүргийн дотор, Сонгинохайрхан дүүргийн дотор, Чингэлтэй дүүргийн дотор, Наркологийн төв тус бүр 15-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 6-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 6 сарын хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдлийн мэдээ

№	Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БНЭМТ	БГДЭМТ	БЗД НЭ	СБДНЭ	ХУДНЭ	СХДНЭ	Наркологи йн эмчлэл
1	Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	88	14	0	10	21	21	0	0	6	0	0
		1-3 хоног	12	6		4		2			6		
		3-6 хоног	12	6		2		11					
		7-14хоног	9	2		4	7	8					
		15-30 хоног	42				14						
		1 сараас дээш	13										
2	Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	147	43	117	56	7	26	8	0	10	0	0
		1-3 хоног	17	15	62	18		3	8		10		
		3-6 хоног	21	15	35	18	4	7					
		7-14хоног	27	7	20	10	3	16					
		15-30 хоног	62	6	0	8							
		1 сараас дээш	20			2							
4	Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	56	0	0	0	0	16	0	0	0	0	0
		1-3 хоног	20					10					
		3-6 хоног	13					6					
		7-14хоног	23										
		15-30 хоног											
		1 сараас дээш											
5	Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
		1-3 хоног											


		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
6	Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	
		1-3 хоног											
		3-6 хоног											
		7-14хоног											
		15-30 хоног											
		1 сараас дээш											
7	Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	130	
		1-3 хоног										45	
		3-6 хоног										61	
		7-14хоног										17	
		15-30 хоног										7	
		1 сараас дээш											

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 6 дугаар сард 23232 дуудлага бүртгэгдсэний 40.7 %-ийг 0-20 минутад, 31.8 %-ийг 21-40 минутад, 16.8%-ийг 41-60 минутад, 10.7 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.


Нийслэлийн түргэн тусламжийн төвд 4, 5, 6 саруудад ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/

№	Үзүүлэлт	4 сар		5 сар		6 сар		
		Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	Дуудлагын тоо	Хувь	
1	Нийт дуудлага	21416	100%	23191	100%	23232	100%	
2	Хүлээгдлийн минут	0-20 минут	8637	40.3%	9588	41.3%	9453	40.7%
3		21-40 минут	4756	22.2%	7328	31.6%	7380	31.8%
4		41-60 минут	4550	21.3%	3499	15.1%	3904	16.8%
5		1 цагаас дээш	3473	16.2%	2776	12.0%	2495	10.7%

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний 2018 оны сүүлийн 3 сарын хүлээгдлийн мэдээг графикаар харуулахад:



Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2018 оны эхний 6 сарын хугацаанд ирсэн нийт дуудлагын тоо:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА